



**ДУНДГОВЬ АЙМГИЙН
ГЭР БҮЛ, ХҮҮХЭД, ЗАЛУУЧУУДЫН ХӨГЖЛИЙН ГАЗРЫН
ДАРГЫН ТУШААЛ**

2020 оны 02 сарын 10 өдөр

Дугаар A/19

Мандалговь

“Сар шинэ–2020” хүүхдийн аюулгүй байдалд
анхаарах хэсэгчилсэн үйл ажиллагаа
зохион байгуулах тухай

Хүүхэд хамгааллын тухай хуулийн 10 дугаар зүйлийн 10.2, 18 дугаар зүйлийн 18.2.1, 18.2.4, Төсвийн тухай хуулийн 16 дугаар зүйл 16.5.5 дахь заалтуудыг тус тус үндэслэн ТУШААХ нь:

1. “Сар шинэ – 2020” хүүхдийн аюулгүй байдалд анхаарах хэсэгчилсэн үйл ажиллагааг 2020 оны 02 дугаар сарын 10-27-ны өдрүүдэд зохион байгуулсугай.
2. Үйл ажиллагаанд хяналт тавьж ажиллах ажлын хэсгийг 1 дүгээр, төсвийг 2 дугаар хавсралтаар тус тус баталсугай.
3. Шаардагдах зардалд 1151100 (Нэг сая нэг зуун тавин нэг мянга нэг зуун) төгрөгийг Нийгмийн бүлэгт чиглэсэн хөтөлбөрөөс санхүүжүүлэхийг нягтлан бодогч (С.Чинбат)-д зөвшөөрсүгэй.
4. Сар шинэ-2020 хүүхдийн аюулгүй байдалд анхаарах хэсэгчилсэн үйл ажиллагаанд хяналт тавьж ажиллахыг Хүүхэд хамгаалал, залуучуудын асуудал хариуцсан мэргэжилтэн, ажлын хэсгийн ахлагч (Ш.Эрдэнэсүвд), гишүүдэд үүрэг болгосугай.
5. Үйл ажиллагаанд хяналт тавьж, үр дүнг 2020 оны 03 дугаар сарын 25-ны өдрийн дотор Даргын дэргэдэх зөвлөлд танилцуулахыг Хүүхэд хамгаалал, залуучуудын асуудал хариуцсан мэргэжилтэн, ажлын хэсгийн ахлагч (Ш.Эрдэнэсүвд)-д даалгасугай.

ДАРГА



Ц. ГАНЗОРИГ

48119003